



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/425

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэгийн  
балансаас хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 13,786,865 /арван гурван сая долоон зуун наян зургаан мянга найман зуун жаран таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянзүрх дүүргийн 146 дугаар цэцэрлэгийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэг /С.Батцэцэг/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Баянзүрх дүүргийн 146 дугаар цэцэрлэг /С.Ариунбаяр/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэг /С.Батцэцэг/, Баянзүрх дүүргийн 146 дугаар цэцэрлэг /С.Ариунбаяр/-т тус тус үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
 даргын 2020 оны 09 дүгээр сарын 22 ны өдрийн  
 А.Х.Б. тоот тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашигла лтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагд- сан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
Тавилга, эд хогшил										
1	Гадна тоглоомын талбайн гулсуур	Гадна тоглоомын гулсуурны иж бүрдэл /хуванцар/	2020	ш	1	13786865.0	13 786 865.00	-	13 786 865.00	БЗД-ийн 146 дугаар цэцэрлэгт
Тавилга, эд хогшлын дүн							13 786 865.00	-	13 786 865.00	
Нийт хөрөнгийн дүн							13 786 865.00	0.00	13 786 865.00	